



БАЛАНСЫН АРГАЧЛАЛЫН МАТРИЦ ШИНЖИЛГЭЭ

Б.Баттөмөр¹

Хураангуй: Энэхүү ажлаар МУ-ын Балансын Аргачлалын Матрицыг байгуулж, Монголбанк, Засгийн газар, хадгаламжийн байгууллагууд, бусад санхүүгийн байгууллагууд, иргэд, улсын болон хувийн ААН-үүд, оршин суугч бусын хоорондын санхүүгийн урсгалын сүлжээг байгуулж, эрсдэлийг шинжиллээ. Түүнчлэн энэхүү ажилд бусад санхүүгийн байгууллагуудын мэдээллийг өргөн цар хүрээтэйгээр хамруулснаараа онцлог юм. МУ-ын эдийн засагт санхүүгийн нийт хөрөнгө, өр төлбөр 2024 оны байдлаар 387 их наяд төгрөгт байгаагаас, 142 их наяд нь төгрөгөөр, 244 их наяд төгрөг нь гадаад валютаар байна. Эдийн засагт оршин суугч бус, иргэд, бусад санхүүгийн байгууллагууд цэвэр хөрөнгөтэй байгаа бол Засгийн газар, Монголбанк, улсын болон хувийн ААН-үүд нь цэвэр өр төлбөртэй байна. Секторуудын хөрөнгө, өр төлбөрийн бүтцэд валютын ханшийн болон өрийн хөрөнгийн нийцгүй байдал үүсэж, төгрөгийн ам.доллартой харьцах ханш 10 хувиар сулрахад МУ-ын цэвэр өр төлбөр ДНБ-ний 19%-тай тэнцүү хэмжээгээр нэмэгдэж байгааг харууллаа. Нийцгүй байдлууд үүссэнээр санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж болохыг ОУ-ын туршлага харуулдаг. Иймээс энэ чиглэлд анхаарч, зохих хяналтыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Түлхүүр үгс: *Балансын аргачлалын матриц, секторуудын тайлан тэнцэл*

JEL ангилал: *E44, G01, G15, H63, E58*

¹ Монголбанк, ССГ, Статистикийн хэлтэс, Эдийн засагч, Цахим хаяг:

battumur.b@mongolbank.mn

Энэхүү ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно. Мөн энэхүү ажлыг гүйцэтгэхэд дэмжиж, үнэтэй зөвлөгөө өгсөн Монголбанкны Статистикийн хэлтсийн захирал Б.Батсүрэн, Судалгааны хэлтсийн захирал Б.Дуламзаяа болон бусад судлаачдад хувийн зүгээс гүн талархал илэрхийлье.

I. Удиртгал

1.1 Шаардлага

Балансын аргачлалын матриц (БАМ, Balance Sheet Approach Matrix) нь эдийн засгийн секторуудын тайлан тэнцэлд суурилан үүсэж болох боломжит эрсдэл, эмзэг байдлыг шинжилдэг аргачлал юм. Азийн санхүүгийн хямрал (1997), Дэлхийн санхүүгийн хямрал (2008)-уудын туршлагаас харахад хямрал нь эдийн засгийн нэг сектороос бусад секторуудад дамжсан шинж чанартай байв. Улмаар Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гаас эдийн засгийн секторууд хоорондын уялдаа, холбоог үлдэгдэл (stock) тоон мэдээлэлд тулгуурлан шинжлэхээр тус аргачлалыг танилцуулсан.

Энэхүү матрицыг Монгол Улсад байгуулснаар үүсэх давуу талуудыг дурдвал:

1. Секторуудын эрсдэл дамжихаас сэргийлэх

Уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай манай улсын эдийн засагт гадаад эдийн засгийн шок (түүхий эдийн үнийн уналт, Хятадын эрэлт буурах гэх мэт) олон сувгаар дамжин нөлөөлдөг. Энэхүү матриц нь эдгээр сувгуудыг (ханшийн, өөрийн хөрөнгийн, хугацааны нийцгүй байдлуудаар) илрүүлж, хямралын “домино эффект”-ийг тодорхой хугацааны өмнө илрүүлэх боломжийг олгоно.

2. Олон Улсын байгууллага, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх, судалгаа, шинжилгээ хийх

ОУВС (2025), Дэлхийн Банк (2023), Азийн Хөгжлийн Банк (2025)-ны тайлангуудад Монгол Улсыг өрийн дарамтын өндөр эрсдэлтэй, гадаад шоконд эмзэг гэж дүгнэсэн. Энэхүү матрицыг нэвтрүүлж, жил бүр олон нийтэд тайлагнаснаар Монгол Улс хөгжиж буй орнуудын жишигт нийцэж байгааг харуулна. Мөн цаашид тус матрицад суурилан судалгаа хийх, сценарь шинжилгээ хийх боломжийг олгоно. Түүнчлэн БНСУ, Чили, Бразил, Исланд болон Зүүн Европын Улсуудын төв банкууд балансын аргачлалын матрицыг ашиглан эдийн засгийн эмзэг байдлын шинжилгээг хийж байна.

1.2 Судлагдсан байдал

Л.Дөлгөөн, Б.Мөнхбаяр (2017) нар 2016 оны байдлаарх Монгол Улсын балансын аргачлалын матрицыг судалсан байна. Үр дүнгээс үзэхэд 2016 онд манай улс ДНБ-ий 143%-тай тэнцэх хэмжээний гадаад валютын цэвэр өглөгтэй байсан бөгөөд тухайн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалтаас илүүтэйгээр гадаад өр, зээлээр валютын орох урсгалаа нэмэгдүүлсэн нь хөрөнгийн бүтцийн эрсдэлийг нэмэгдүүлж байжээ. Мөн Засгийн газар, Төв банк болон хувийн секторын хувьд цэвэр өглөгтэй. Үүний дийлэнхийг гадаад валютын өглөг эзэлж байсан нь эдгээр секторууд валютын ханшийн шоконд өртөх эмзэг байдал өндөр байсныг харуулжээ.

Д.Ган-Очир, С.Номин, Г.Мөнхбаяр, Б.Анхцэцэг нар (2019) 2012 оноос 2018 он хүртэлх тоон мэдээллээр балансын аргачлалын матрицыг байгуулан судалжээ. Судалгааны үр дүнд, 2016 оны байдлаар төгрөгийн ханш 10%-иар сулрахад ДНБ-ий 29%-тай тэнцүү хэмжээгээр МУ-ын цэвэр позиц өсөхийг харуулсан байна.


Судалгаагаар дотоод, гадаад тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад санхүүжилтийн хэрэгцээ өндөр байгааг онцолжээ.

1.3 Статистик

Балансын аргачлалын матрицад Мөнгө санхүүгийн статистик, Гадаад секторын статистик, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланг ашигласан². Тодруулбал, Мөнгө, санхүүгийн статистикаас санхүүгийн байгууллага (Төв банк, банкууд, ХЗХ, бусад санхүүгийн байгууллагууд), санхүүгийн бус байгууллага (Улсын байгууллага, хувийн байгууллага, иргэд) болон оршин суугч бусын хоорондох санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг; Гадаад секторын статистикаас Монгол Улсын оршин суугч болон оршин суугч бусын хоорондын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг; Засгийн газрын нэгдсэн тайлан тэнцлээс төсвийн байгууллага болон бусад секторын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг тус тус нэгтгэж авсан. Дээрх статистикууд нь Нягтлан бодох бүртгэлийн дансны давхар бичилтийн аргаар, институцийн нэгж, секторын ангилал, үлдэгдэл (stock) аргаар боловсруулж байгаагаар ижил юм.

1.4 Тайлан тэнцлийн зарчим

Зураг 1. Секторуудын тайлан тэнцлийн хоорондын нийтлэг хамаарал



Тайлбар: Санхүүгийн байгууллагууд иргэд, ААН-үүдээс харилцах, хадгаламж татах замаар эх үүсвэр бүрдүүлж, зээл олгодог. Засгийн газар нь тухайн улсын гадаад валютын нөөцийг эзэмшиж, дотоод болон гадаадын зах зээлд үнэт цаас гаргадаг. Харин оршин суугч бус нь дотоодын эдийн засагт гадаад валютын зээл олгох, гадаадын зах зээлд гаргасан үнэт цаасыг эзэмшиж хөрөнгө оруулах нь нийтлэг байдаг. Санхүүгийн бус байгууллага- Иргэд, улсын байгууллага, хувийн байгууллага
 Эх сурвалж: Судлаачийн дүрслэл

² Монголбанк. (2025). Статистикийн цахим хуудас. <https://stat.mongolbank.mn>, Үндэсний Аудитын Газар. (2025). Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. <https://d.parliament.mn/tusul/1d6f96e3-5468-4a97-8f02-5ce68246b9b5>

Эдийн засгийн секторуудын тайлан тэнцэл нь хоорондоо нягт, нарийн холбоотой. Нэг секторын хөрөнгө (актив) нь нөгөө секторын өр төлбөр (пассив) болж байдаг (Зураг 1). Манай улсын хувьд секторын ангиллыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А-294 дугаар тушаалаар батлагдсан “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-д заасан бөгөөд ОУВС-гийн Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлагатай нийцтэй байдаг (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Секторуудын тодорхойлолт

Сектор	Тодорхойлолт
Эдийн засгийн харьяат	Эдийн засгийн харьяат (оршин суугч) гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, гадаадад 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэдийг тооцно.
Эдийн засгийн харьяат бус (Оршин суугч бус)	Эдийн засгийн харьяатаас бусад гадаадын болон Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тооцно.
Санхүүгийн байгууллага	
Хадгаламжийн байгууллага	Хадгаламжийн байгууллагад харилцах, хадгаламж хэлбэрээр хөрөнгө татдаг болон эсвэл эх үүсвэр нь харилцах, хадгаламжийг орлуулж болох эх үүсвэр татдаг санхүүгийн байгууллагуудыг хамруулдаг. Манай улсын хувьд арилжааны банкууд, хадгаламж зээлийн хоршоодыг хамруулж байна.
Бусад санхүүгийн байгууллага	Төв банк, хадгаламжийн байгууллагаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудыг оруулах бөгөөд банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани, даатгалын компани (НДЕГ нь Засгийн газрын харьяа байгууллага тул энд хамрагдахгүй), МИК Холдинг ХК, Монгол Улсын Хөгжлийн банк болон бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд Монгол Улсад хамрагдана.
Санхүүгийн бус байгууллага	
Засгийн газар	Яамдууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, Татварын ерөнхий газар, Улсын гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, тэдгээрийн харьяа хэлтсүүд, дунд сургууль, цэцэрлэг болон бусад улсын төсвийн байгууллагуудыг багтаасан том хэмжээний цогц сектор юм. Улсын төсвийн байгууллагууд төсвөөс тодорхой хувиар санхүүждэг эсвэл тухай оны төсвийн тухай хуульд тусгагдсан байгууллагуудыг хамруулдаг.
Өрх иргэдэд үйлчлэгч ашгийн байгууллагууд	Төлбөргүй эсвэл бага хэмжээний хураамж бүхий зах зээлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээг өрх гэр, иргэдэд үзүүлдэг ашгийн бус байгууллагууд юм. Ашгийн бус байгууллагууд нь тусламжаар, гишүүдийн хураамжаар санхүүждэг бөгөөд эдгээрт худалдааны нэгдэл, мэргэсэн нийгэмлэгүүд, хэрэглэгчдийг хамгаалах нийгэмлэг, улс төрийн намууд, сүм, хийдүүд, нийгэм, соёл, спортын клуб зэрэг орно. Мөн бусад байгууллагуудаас сайн дураар санхүүжсэн хүмүүнлэгийн тусламжийн байгууллагууд орно. Харин хувийн сургууль, цэцэрлэг орохгүй.

Өрх гэр /иргэд/	Өрх гэр нь хэсэг бүлэг хүмүүс нэг байр сууцанд амьдарч, орлого, зарлагаа нэгтгэн зарцуулдаг. Өрх гэрийн секторыг тодруулгад иргэд гэсэн ангиллаар харуулсан болно.
Хувийн байгууллага	Засгийн газрын харьяа бус бусад бүх санхүүгийн бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч байгууллагуудыг хамруулна. Гол хяналтыг авч байгаа байдлаар, өөрөөр хэлбэл өмчийн 51 болон түүнээс дээш хувь хувийн өмчлөлтэй бол тус секторт хамруулна.
Улсын байгууллага	Санхүүгийн бус үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг Засгийн газрын харьяа байгууллагыг хамруулдаг. Засгийн газрын харьяа гэдгийг удирдлагыг чөлөөлөх, томилох зэргээр байгууллагын ерөнхий удирдлагад зохицуулалт хийхийг хэлнэ. Тухайн байгууллагын өмчийн 51 болон түүнээс дээш хувийг төр эзэмшдэг бол тус секторт хамруулна. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд, улсын их дээд сургуулиудыг хамруулна.

Эх сурвалж: Олон улсын валютын сан. (2016). Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаал. (2017).

II. Монгол Улсын эдийн засгийн статистикийн тойм

2.1 Санхүүгийн байгууллагууд

Монгол Улсын санхүүгийн салбарт 2024 оны байдлаар 12 банк, 573 банк бус санхүүгийн байгууллага, 178 хадгаламж зээлийн хоршоо, 307 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, аудитор, 2,504 даатгалын төлөөлөгч, 53 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2024 онд 116.5 их наяд төгрөгт хүрэв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Санхүүгийн салбарын нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр

Он	Монголбанк	Банкууд	Хадгаламж, зээлийн хоршоод	Бусад санхүүгийн байгууллагууд	Нийт
2024	29,571	71,424	357	15,184	116,535
2023	26,196	57,111	307	12,922	96,536
Өөрчлөлт	+3,375	+14,313	+50	+2,262	+20,000

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, МИК Холдинг ХК, ҮЦСК ХХК (2025)

Хүснэгт 3. Бусад санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр

Он	ББСБ	МИК Холдинг ХК	МУХБ	Даатгалын компаниуд	ҮЦСК ХХК	Нийт
2024	7,127	5,216	2,131	663	46	15,184
2023	4,672	5,308	2,278	551	113	12,922
Өөрчлөлт	+2,455	-92	-146	+111	-67	+2,262

ББСБ: Банк бус санхүүгийн байгууллага

МУХБ: Монгол Улсын Хөгжлийн банк

ҮЦСК: Үнэт цаасны санхүүжилтийн корпорац

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, МИК Холдинг ХК, ҮЦСК ХХК (2025)

2.2 Санхүүгийн бус байгууллага

1. Засгийн газар, улсын байгууллага

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 122,238.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 14.6 хувиар нэмэгдсэн байна (Хүснэгт 4). Энэхүү дүн нь улсын байгууллагууд буюу төрийн өмчит үйлдвэрлэлийн газар болон орон нутгийн өмчит үйлдвэрлэлийн газрууд багтаасан дүн юм.

Хүснэгт 4. Нийт хөрөнгө, өр төлбөр 2024 оны байдлаар, тэрбум төгрөгөөр

Он	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Өмчийн дүн
2024	122,238	57,724	64,514
2023	106,711	55,194	51,516
Өөрчлөлт	+15,528	+2,529	+12,998

Эх сурвалж: Үндэсний Аудитын газар (2025)

2. Оршин суугч бус

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш чиглэсэн нийт хөрөнгө оруулалт (актив) 2024 оны эцсийн байдлаар 9,859 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүний 56%-ийг гадаад валютын албан нөөц, 27%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, 6%-ийг багцын хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Харин Монгол Улсын эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж, байгууллагуудад хийгдсэн гадаадын нийт хөрөнгө оруулалт (пассив) 53,698 сая ам.долларт хүрч, үүний 62%-ийг шууд хөрөнгө оруулалт, 7%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 31%-ийг бусад хөрөнгө оруулалт эзэлж байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллороор

Үзүүлэлт	2023	2024	Өөрчлөлт
I. Гадаад актив	8,792	9,859	1,067
Шууд хөрөнгө оруулалт	1,024	1,127	103
Багцын хөрөнгө оруулалт	486	547	62
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	4	4
Бусад хөрөнгө оруулалт	2,361	2,670	309
Нөөц актив	4,921	5,510	588
II. Гадаад пассив	50,359	53,698	3,339
Шууд хөрөнгө оруулалт	30,697	33,482	2,785
Багцын хөрөнгө оруулалт	2,703	3,749	1,045
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	17	17
Бусад хөрөнгө оруулалт	16,959	16,450	-509
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-41,567	-43,839	-2,272

Гадаад хөрөнгө оруулалтын позиц: Гадны улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө (гадаад актив) болон Монгол Улсад байршиж буй бусад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө (гадаад пассив)-ийн хуримтлагдсан үлдэгдлийг харуулдаг статистик юм.

Эх сурвалж: Монголбанк (2024)

III. Секторуудын нийцгүй байдал

Эдийн засгийн секторуудын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүтцээс хамааран балансын аргачлалын матрицаас дараах нийцгүй байдлууд (mismatches) илэрнэ. Үүнд,

- *Валютын ханшийн нийцгүй байдал:* Санхүүгийн хөрөнгийг байршуулсан валют болон эх үүсвэр татсан валют нь өөр байгаагаас үүдэн ханшийн өөрчлөлтөд хүлээх эрсдэл юм. Тодруулбал, гадаад валютаар эх үүсвэр татаж дотоодын валютаар хөрөнгө байршуулснаар, гадаад валютын ханш чангарахад өр төлбөрийн зардал өсөх, ханшийн дахин үнэлгээний алдагдлыг нэмэгдүүлж өөрийн хөрөнгийг муутгадаг. Хеджинг хийгээгүй (Unhedged) гадаад валютын эх үүсвэр нь зээлдэгчийг валютын ханшийн эрсдэлтэй болгодог. Засгийн газар нь ОУ-ын зах зээлд гадаад валютын эх үүсвэр татдаг бол татварын орлого нь дотоодын валютаар байдаг тул дотоодын валютын сулралтад эмзэг болгодог (Mislav Brkić, 2021).
- *Хугацааны нийцгүй байдал:* Хөрөнгө, өр төлбөрийн хугацаа зөрсөн үед ролloverын эрсдэл үүсдэг. Энэ нь өр төлбөрийн гэрээний хугацаа дуусахад дахин эх үүсвэр татах боломжгүй байх эсвэл илүү өндөр зардалтай эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай болгодог. Үүний тод жишээ нь банкууд богино хугацаатай эх үүсвэрийг бусад санхүүгийн байгууллагаас татаж, иргэд, ААН-үүдэд дунд, урт хугацааны зээл (*Хэрэглээний, бизнесийн зээл болон бусад*) олгодог. Ийнхүү банкууд санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаатай зээлээ эргэн төлөх үед төлбөрийн чадваргүй болох эрсдэл үүсдэг.
- *Өөрийн хөрөнгийн бүтцийн нийцгүй байдал:*
 - *Төлбөрийн чадварын нийцгүй байдал:* Өр төлбөр нь хөрөнгийн дүнгээс хэтэрч өөрийн хөрөнгө (-) дүнтэй болохыг илтгэнэ. Аж ахуйн нэгж нь урт хугацаанд алдагдалтай ажилласнаар алдагдал хуримтлагдаж өөрийн хөрөнгө (-) дүнтэй болох нь нийтлэг байдаг.
 - *Өөрийн хөрөнгө-Зээлийн харьцаа:* Зээлийн өр төлбөрийн хэмжээ нь өөрийн хөрөнгөтэй харьцуулахад нэмэгдэх нь өөрийн санхүүжилтээс бус зээлийн санхүүжилтээс хамаарч буйг харуулдаг.

3.1 Тоон мэдээлэл цуглуулалт

Матрицад ашигласан санхүүгийн байгууллагуудын мэдээллийг Монголбанкны мөнгө санхүүгийн статистик, СЗХ, МИК Холдинг ХК, ҮЦСК ХХК-ий тайлангуудаас, Засгийн газрын мэдээллийг Үндэсний Аудитын газрын МУ-ын ЗГ-ын нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, оршин суугч бус секторын мэдээллийг Монголбанкны гадаад секторын статистикаас, санхүүгийн бус байгууллагуудын хувьд албан ёсны тайлан тэнцэл байхгүй тул бусад секторуудын тайлан тэнцлийг ашигласан (Хүснэгт 6). Дээрх мэдээллүүдийг матрицад ОУВС-гийн Стандартчилсан Тайлагналын Маягт (SRF/Standartized report form)-ын дагуу оруулсан (Хүснэгт 7).

Хүснэгт 6. Статистикийн эх сурвалж

Сектор	Эх сурвалж
Санхүүгийн байгууллагууд	ОУВС-гийн Стандартчилсан Тайлагналын Маягт. Монголбанк <ul style="list-style-type: none"> • 1SR – Монголбанк • 2SR – Банкууд, ХЗХ • 4SR – БСБ /Монгол Улсын Хөгжлийн Банк, Банк бус санхүүгийн байгууллага, МИК Холдинг ХК, ҮЦСК ХХК, Даатгалын компаниуд. СЗХ/
Засгийн газар	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан. Үндэсний Аудитын Газар (Стандартчилсан Тайлагналын Маягт (SRF)-д хөрвүүлсэн)
Санхүүгийн бус байгууллага:	Улсын байгууллага, хувийн байгууллага, иргэдийн хувьд албан ёсны тайлан тэнцэл байхгүй тул үүнд бусад секторуудын тайлан тэнцлийг ашигласан. Жишээлбэл, иргэдийн банкуудаас авах авлагыг банкуудын иргэдээс татсан харилцах, хадгаламжаар төлөөлүүлсэн.
Оршин суугч бус	Эдийн засгийн харьяат бус– Гадаад хөрөнгө оруулалтын позиц. ИР. Монголбанк

Хүснэгт 7. Балансын Аргачлалын матрицын тоон мэдээллийн эх сурвалж

Өр төлбөр \ Хөрөнгө	Хөрөнгө					
	Монголбанк	ЗГ	Хадгаламжийн байгууллага	БСБ	Санхүүгийн бус байгууллага	Оршин суугч бус
Монголбанк		SRF 1SR	SRF 2SR	SRF 4SR	SRF 1SR	ИР
Засгийн газар	SRF 1SR		SRF 2SR	SRF 4SR	GFS	ИР
Хадгаламжийн байгууллага	SRF 1SR	SRF 2SR	SRF 2SR	SRF 4SR	SRF 2SR	ИР
БСБ	SRF 1SR	SRF 4SR	SRF 2SR	SRF 4SR	SRF 4SR	ИР
Санхүүгийн бус байгууллага	SRF 1SR	GFS	SRF 2SR	SRF 4SR		ИР
Оршин суугч бус	SRF 1SR	ИР	SRF 2SR	SRF 4SR	ИР	

Тайлбар : Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- ББСБ, МУХБ, МИК Холдинг ХХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд

SRF- Standardized report form, Стандартчилсан Тайлагналын Маягт: Олон Улсын Валютын Сангийн гишүүн орнуудад мөнгө, санхүүгийн мэдээллийг тууштай, харьцуулагдахуйц байдлаар тайлагнахад ашигладаг загвар юм.

ИР- International Investment Position, Гадаад хөрөнгө оруулалтын позиц: Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө (гадаад актив) болон Монгол Улсад байршиж буй бусад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө (гадаад пассив)-ийн хуримтлагдсан үлдэгдлийг харуулдаг статистик юм.

GFS- Government Finance Statistics, Засгийн газрын статистик: Энэхүү мэдээлэлд 2024 оны Засгийн газрын аудитлагдсан тайланг ашигласан.


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, Олон Улсын Валютын Сангийн аргачлал

IV. Матрицын шинжилгээ

4.1 Санхүүгийн нийт хөрөнгө, өр төлбөр

Монгол Улсын эдийн засаг дахь нийт санхүүгийн хөрөнгө 2024 оны байдлаар 386.6 их наяд төгрөг байна.

Зураг 2. Сектор хоорондын санхүүгийн урсгал, 2024 оны байдлаар



Тайлбар : Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- ББСБ, МУХБ, МИК Холдинг ХХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол; Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Оршин суугч бус нь 184.1 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгөтэй.

- Үүнээс улсын болон хувийн хэвшлийн ААН-үүдэд оруулсан 140.2 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө (Оюу Толгой ХХК гэх мэт);
- МУ-ын Засгийн газарт олгосон Гадаадын Засгийн газруудын хөнгөлөлттэй зээл болон ОУ-д гаргасан МУ-ын Засгийн газрын бондын 28.7 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгө;
- Хадгаламжийн байгууллагууд оруулсан 9.5 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын зээл, үнэт цаас, харилцах, хадгаламж болон бусад хөрөнгө;
- Монголбанк дахь 3.8 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцлийн шугамын үлдэгдэл болон бусад хөрөнгө;
- БСБ дахь 2.0 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын зээл, үнэт цаас болон бусад хөрөнгө багтаж байна.

Хадгаламжийн байгууллагууд 71.1 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Иргэдэд олгосон 22.5 их наяд төгрөгийн зээл, хуримтлуулсан хүү;
- Монголбанк дахь 21.8 их наяд төгрөгийн заавал байлгах нөөц, хадгаламж, Төв банкны үнэт цаас, хуримтлуулсан хүү;
- Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд дэх 14.8 их наяд төгрөгийн зээл, үнэт цаас, хувьцаа болон бусад хөрөнгө, хуримтлуулсан хүү;
- Бусад банкууд дахь 3.8 их наяд төгрөгийн зээл, репо, харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;
- Гадаадын санхүүгийн байгууллага дахь 2.9 их наяд төгрөгийн гадаад валютын зээл, харилцах, хадгаламж, зээл, үнэт цаас, хуримтлуулсан хүү;
- Засгийн газартай холбоотой үнэт цаас болон бусад хөрөнгийн дүн 2.8 их наяд төгрөг байна.

Иргэд 37.5 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Хадгаламжийн байгууллагуудад байршуулсан 31.5 их наяд төгрөгийн харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;
- БСБ дахь 5.4 их наяд төгрөгийн итгэлцлийн үйлчилгээний авлага, хувьцаа, хуримтлуулсан хүү;
- Монголбанк дахь хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгө 0.5 их наяд төгрөг;
- Хувь хүмүүсийн Засгийн газартай холбоотой хөрөнгө нь 0.1 их наяд төгрөгийн урьдчилж олсон орлого болон бусад хөрөнгө байна.

Монголбанк 32.8 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Гадаадын санхүүгийн байгууллагад 18.8 их наяд төгрөг (5.5 тэрбум ам.доллар)-тэй тэнцэх гадаад валютыг байршуулсан нь Монгол Улсын гадаад валютын албан нөөц байна. Монголбанк нь Монгол Улсын гадаад валютын нөөцийг удирдаж, гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэг хүлээдэг (2025 оны 7 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 5.4 тэрбум ам.доллар байна).
- Хадгаламжийн байгууллагууд дахь 4.4 их наяд төгрөгийн зээл, овернайт хадгаламж, бусад хөрөнгө;
- БСБ дахь 3.1 их наяд төгрөгийн үнэт цаас, зээл, хуримтлуулсан хүү;
- Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүдийн гаргасан 0.9 их наяд төгрөгийн үнэт цаас, бусад хөрөнгө;
- Засгийн газрын үнэт цаас, бусад хөрөнгө болон Монголбанкны өөрийн хөрөнгө нийт 5.6 их наяд төгрөг (*Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанкны пассив нь активаас хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан байдаг*) багтаж байна.

Хүснэгт 8. Балансын аргачлалын матриц 2024 оны байдлаар, их наяд ₮

2024								
Хөрөнгө Өр төлбөр	ЗГ	МБ	Хад/ байгууллага	БСБ	Улсын болон хувийн ААН	Иргэд	Оршин суугч бус	НИЙТ
Засгийн газар		6.9	3.8	0.1	2.6	0.5	0.0	13.9
Төгрөг		1.6	3.4	0.1	2.6	0.5	0.0	8.2
Гадаад валют		5.3	0.4	0.0	0.0	0.0	0.0	5.7
Монголбанк	5.6		4.4	3.1	0.9	0.0	18.8	32.8
Төгрөг	5.6		4.4	3.1	0.9	0.0	0.0	13.9
Гадаад валют	0.0		0.0	0.0	0.0	0.0	18.8	18.9
Хадгаламжийн байгууллага	2.8	21.8	3.8	2.4	14.8	22.5	2.9	71.1
Төгрөг	0.0	18.2	2.7	2.3	12.6	22.4	0.0	58.3
Гадаад валют	2.8	3.5	1.2	0.1	2.2	0.1	2.9	12.8
БСБайгууллага	0.1	0.2	2.5	1.6	3.0	9.7	0.2	17.3
Төгрөг	0.1	0.2	1.3	1.5	2.2	9.6	0.0	14.9
Гадаад валют	0.1	0.0	1.2	0.1	0.7	0.1	0.2	2.4
Улсын болон хувийн ААН	1.4	0.0	16.2	0.4		0.0	11.8	29.9
Төгрөг	1.4	0.0	8.6	0.4		0.0	0.0	10.4
Гадаад валют	0.0	0.0	7.7	0.1		0.0	11.8	19.5
Иргэд	0.1	0.5	31.5	5.4	0.0		0.0	37.5
Төгрөг	0.1	0.5	30.6	5.3	0.0		0.0	36.5
Гадаад валют	0.0	0.0	0.9	0.1	0.0		0.0	1.0
Оршин суугч бус	28.7	3.8	9.5	2.0	140.2	0.0		184.1
Төгрөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		0.0
Гадаад валют	28.7	3.8	9.5	2.0	140.2	0.0		184.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	38.8	33.1	71.8	15.0	161.4	32.7	33.7	386.6
Төгрөг	7.2	20.5	51.0	12.7	18.3	32.6	0.0	142.3
Гадаад валют	31.6	12.6	20.8	2.3	143.1	0.2	33.7	244.3

Тайлбар : Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- БСБ, МУХБ, МИК Холдинг ХХК, Даатгалын компаниуд, УЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол; Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд 29.9 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Хадгаламжийн байгууллагууд дахь 16.2 их наяд төгрөгийн харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;
- Оршин суугч бусад байршуулсан 11.8 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;

- Аж ахуй нэгжийн Засгийн газартай холбоотой хөрөнгө нь 1.4 их наяд төгрөгийн урьдчилж олсон орлого болон бусад хөрөнгө;
- БСБ дахь 0.4 их наяд хөрөнгө нь итгэлцлийн үйлчилгээнд байршуулсан хөрөнгө, үнэт цаас, хуримтлуулсан хүү багтаж байна.

Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд хадгаламжийн байгууллагуудын зээл болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс хамаарсан байгаа нь дотоод, гадаад эдийн засгийн орчны нөхцөл байдлаас эмзэг болгож байна. Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүдийн хадгаламжийн байгууллагуудад өгөх өглөг нь **ДНБ-ий 19%**, оршин суугч бусад өгөх өглөг **ДНБ-ий 175%-тай** тэнцэж байна.

Бусад санхүүгийн байгууллагууд 17.3 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Иргэдэд олгосон банк бус санхүүгийн байгууллагуудын зээл, МИК ОССК ХХК-ий багцалж худалдаж авсан ипотекийн зээл, факторингийн тооцооны авлага болон бусад хөрөнгө нь 9.7 их наяд төгрөг;
- Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүдэд олгосон зээл, үнэт цаас, факторингийн тооцооны авлага, хувьцаа болон бусад хөрөнгө нь 3.0 их наяд төгрөг;
- Хадгаламжийн байгууллагууд дахь 2.5 их наяд төгрөг нь харилцах, хадгаламж, зээл, хувьцаа, хуримтлуулсан хүү;
- Гадаадын санхүүгийн байгууллага дахь 0.2 их наяд төгрөгийн гадаад валют нь зээл, харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;
- Монголбанк дахь 0.1 их наяд төгрөгийн хөрөнгө багтаж байна.

Засгийн газар 13.9 их наяд төгрөгийн хөрөнгөтэй.

- Монголбанк дахь 6.9 их наяд төгрөг нь харилцах, хадгаламж, хуримтлуулсан хүү;
- Хадгаламжийн байгууллагууд дахь 3.8 их наяд төгрөг нь харилцах, хадгаламж (ЭМД, НДС болон бусад), санхүүжилт, хуримтлуулсан хүү;
- Улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд дэх 2.6 их наяд төгрөг нь дотоод, гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага, үнэт цаас болон бусад хөрөнгө;
- Иргэдийн хувьд ажиллагчидтай холбогдсон авлага, сургалтын төрийн сангийн зээл болон бусад хөрөнгө нь 0.5 их наяд төгрөг;
- БСБ дахь 0.1 их наяд төгрөг нь төслийн зээл болон бусад хөрөнгө багтаж байна (*Дэлгэрэнгүй матрицыг Хавсралт 1-т харуулав*).

Хүснэгт 9. Балансын аргачлалын матриц, нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар, 2024 оны байдлаар

2024								
Хөрөнгө Өр төлбөр	ЗГ	МБ	Хад/ байгууллага	БСБ	Улсын болон хувийн ААН	Иргэд	Оршин суугч бус	НИЙТ
Засгийн газар		8.6%	4.8%	0.1%	3.3%	0.6%	0.0%	17.4%
Төгрөг		2.0%	4.3%	0.1%	3.3%	0.6%	0.0%	10.3%
Гадаад валют		6.6%	0.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	7.1%
Монголбанк	7.1%		5.4%	3.9%	1.1%	0.0%	23.6%	41.0%
Төгрөг	7.1%		5.4%	3.8%	1.1%	0.0%	0.0%	17.4%
Гадаад валют	0.0%		0.0%	0.0%	0.0%	0.0%	23.6%	23.6%
Хадгаламжийн байгууллага	3.5%	27.2%	4.8%	3.1%	18.5%	28.2%	3.6%	88.9%
Төгрөг	0.0%	22.8%	3.3%	2.9%	15.8%	28.1%	0.0%	72.9%
Гадаад валют	3.5%	4.4%	1.5%	0.2%	2.7%	0.1%	3.6%	16.0%
БСБайгууллага	0.2%	0.3%	3.2%	2.0%	3.7%	12.1%	0.2%	21.7%
Төгрөг	0.1%	0.2%	1.6%	1.9%	2.8%	12.0%	0.0%	18.6%
Гадаад валют	0.1%	0.0%	1.6%	0.1%	0.9%	0.1%	0.2%	3.0%
Улсын болон хувийн ААН	1.8%	0.0%	20.3%	0.6%		0.0%	14.7%	37.4%
Төгрөг	1.8%	0.0%	10.7%	0.5%		0.0%	0.0%	12.9%
Гадаад валют	0.0%	0.0%	9.6%	0.1%		0.0%	14.7%	24.4%
Иргэд	0.1%	0.7%	39.5%	6.7%	0.0%		0.0%	46.9%
Төгрөг	0.1%	0.7%	38.3%	6.6%	0.0%		0.0%	45.7%
Гадаад валют	0.0%	0.0%	1.1%	0.1%	0.0%		0.0%	1.2%
Оршин суугч бус	35.9%	4.7%	11.8%	2.5%	175.4%	0.0%		230.3%
Төгрөг	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%		0.0%
Гадаад валют	35.9%	4.7%	11.8%	2.5%	175.4%	0.0%		230.3%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	48.5%	41.4%	89.8%	18.8%	201.9%	41.0%	42.2%	483.5%
Төгрөг	9.1%	25.6%	63.7%	15.9%	22.9%	40.7%	0.0%	177.9%
Гадаад валют	39.5%	15.8%	26.0%	2.9%	179.0%	0.2%	42.2%	305.6%

Тайлбар : Хадгаламжийн байгууллага - Банкууд, ХЗХ; БСБайгууллага- ББСБ, МУХБ, МИК Холдинг ХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Монгол Улсын эдийн засагт 142.3 их наяд төгрөгөөрх хөрөнгө байгаа бол гадаад валютын хөрөнгө нь 244.3 их наяд төгрөгтэй тэнцэж байна (Хүснэгт 8).


Төгрөгийн хөрөнгийг зээлдүүлсэн буюу зээлдүүлэгч (Жишээ нь банк иргэнд зээл олгох үед банк нь зээлдүүлэгч болно.)-ээр нь авч үзвэл, 58.3 их наяд төгрөг нь хадгаламжийн байгууллагуудынх, 36.5 их наяд төгрөг нь иргэдийнх, 14.9 их наяд төгрөг нь БСБ-ынх, 13.9 их наяд төгрөг нь Монголбанкных, 10.4 их наяд төгрөг нь улсын болон хувийн ААН-үүдийнх, 8.2 их наяд төгрөг нь Засгийн газрын хөрөнгө байна. Гадаад валютын хөрөнгийг зээлдүүлэгчээр нь авч үзвэл, 184.1 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь оршин суугч бусынх, 19.5 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь улсын болон хувийн ААН-үүдийнх, 18.9 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь Монголбанкных, 12.8 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь хадгаламжийн байгууллагуудынх, 5.7 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь Засгийн газрынх, 2.4 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь БСБ-ынх, 1.0 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валют нь иргэдийн хөрөнгө байна (Зураг 3).

Энэхүү хөрөнгийг хүлээн авсан сектороор буюу зээлдэгч (Жишээ нь банк иргэнд зээл олгох үед иргэн нь зээлдэгч болно.)-ээр нь авч үзвэл, төгрөгийн зээлдэгчид нь хадгаламжийн байгууллагууд 50.3 их наяд, иргэд 32.6 их наяд, Монголбанк 20.6 их наяд, улсын болон хувийн ААН-үүд 18.3 их наяд, БСБ 12.0 их наяд, Засгийн газар 7.2 их наяд төгрөгийг төлөхөөр байна. Гадаад валютын хөрөнгийн зээлдэгчид нь улсын болон хувийн ААН 143.1 их наяд төгрөгтэй тэнцэх, оршин суугч бус нь 33.7 их наяд төгрөгтэй тэнцэх, Засгийн газар 31.6 их наяд төгрөгтэй тэнцэх, хадгаламжийн байгууллагууд 20.4 их наяд төгрөгтэй тэнцэх, Монголбанк 13.4 их наяд төгрөгтэй тэнцэх, БСБ 2.5 их наяд төгрөгтэй тэнцэх, иргэд 0.2 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын тус тус өр төлбөртэй байна (Зураг 4).

Зураг 3. Санхүүгийн хөрөнгө, валютаар /Зээлдүүлэгчээр/




Зураг 4. Санхүүгийн өр төлбөр, валютаар /Зээлдэгчээр/




Эх сурвалж: Судлаачийн дүрслэл, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Нийт хөрөнгийн 353 их наяд төгрөг нь Монгол Улсын иргэд, ААН-үүд дэх хөрөнгө, 34 их наяд төгрөг нь оршин суугч бус дахь хөрөнгө байна (Зураг 5). Нийт өр төлбөрийн 202 их наяд төгрөг нь Монгол Улсын иргэд, ААН-үүдэд өгөх, 184 их наяд төгрөгийг оршин суугч бусад өгөх өр төлбөр байна (Зураг 6).

Зураг 5. Монгол Улсын иргэд, ААН-үүд дэх хөрөнгө, өр төлбөр



Зураг 6. Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө, өр төлбөр



Эх сурвалж: Судлаачийн дүрслэл, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

4.2 Санхүүгийн цэвэр хөрөнгө

Хүснэгт 10. Санхүүгийн цэвэр хөрөнгө, их наяд ₮, 2024 оны байдлаар


2024								
Хөрөнгө / Өр төлбөр	ЗГ	МБ	Хад/байгууллага	БСБ	Улсын болон хувийн ААН	Иргэд	Оршин суугч бус	НИЙТ
Засгийн газар		1.2	1.0	-0.02	1.2	0.4	-28.7	-24.9
Төгрөг		-4.1	3.4	0.05	1.2	0.4	0.0	1.0
Гадаад валют		5.3	-2.4	-0.06	0.0	0.0	-28.7	-25.9
Монголбанк	-1.2		-18.3	2.9	0.9	-0.5	15.1	-1.1
Төгрөг	4.1		-14.0	2.9	0.9	-0.5	0.0	-6.6
Гадаад валют	-5.3		-4.3	0.0	0.0	0.0	15.1	5.5
Хадгаламжийн байгууллага	-1.0	17.4	0.7	-0.1	-1.4	-9.0	-6.1	0.3
Төгрөг	-3.4	13.8	0.7	1.0	4.1	-8.2	0.0	8.0
Гадаад валют	2.4	3.5	0.0	-1.1	-5.5	-0.8	-6.1	-7.7
БСБайгууллага	0.0	-2.9	0.1	0.6	2.5	4.3	-1.8	2.8
Төгрөг	0.0	-2.9	-1.0	0.7	1.8	4.3	0.0	2.9
Гадаад валют	0.1	0.0	1.1	-0.1	0.7	0.0	-1.8	-0.1
Улсын болон хувийн ААН	-1.2	-0.9	1.4	-2.5	0.0	0.0	-128.4	-131.6
Төгрөг	-1.2	-0.9	-4.1	-1.8	0.0	0.0	0.0	-8.0
Гадаад валют	0.0	0.0	5.5	-0.7	0.0	0.0	-128.4	-123.6
Иргэд	-0.4	0.5	9.0	-4.3	0.0	0.0	0.0	4.8
Төгрөг	-0.4	0.5	8.2	-4.3	0.0	0.0	0.0	4.0
Гадаад валют	0.0	0.0	0.8	0.0	0.0	0.0	0.0	0.8
Оршин суугч бус	28.7	-15.1	6.6	1.8	128.4	0.0	0.0	150.4
Төгрөг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад валют	28.7	-15.1	6.6	1.8	128.4	0.0	0.0	150.4

Тайлбар: Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- ББСБ, МУХБ, МИК Холдинг ХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Эдийн засагт цэвэр хөрөнгөтэй буюу бусад сектор дахь хөрөнгө нь өр төлбөрөөсөө илүү секторууд нь оршин суугч бус 150.4 их наяд, иргэд 4.8 их наяд, БСБ 2.8 их наяд, хадгаламжийн байгууллагууд 0.3 их наяд төгрөгийн хөрөнгө өр төлбөрөөсөө илүү эзэмшиж байна (Зураг 7).

Зураг 7. Сектор хоорондын сүлжээ, 2024 оны байдлаар



Тайлбар: Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- БСБ, МУХБ, МИК Холдинг ХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.

Улаанаар тэмдэглэсэн нь цэвэр зээлдэгч, Ногооноор тэмдэглэсэн нь цэвэр зээлдүүлэгч
Эх сурвалж: Судлаачийн дүрслэл, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Харин цэвэр өр төлбөртэй буюу бусад сектор дахь хөрөнгө нь өр төлбөрөөсөө бага секторууд нь улсын болон хувийн ААН-үүд 131.6 их наяд төгрөгөөр, Засгийн газар 24.9 их наяд, Монголбанк 1.1 их наяд төгрөгөөр хөрөнгө нь өр төлбөрөөсөө бага байна.

4.3 Валютын ханшийн нийцгүй байдал

Эдийн засагт гадаад валютын цэвэр хөрөнгөтэй буюу бусад сектор дахь гадаад валютын хөрөнгө нь гадаад валютын өр төлбөрөөсөө илүү секторууд нь оршин суугч бус 150.4 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын, Монголбанк 5.5 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгө өр төлбөрөөсөө илүү эзэмшиж байна. Харин гадаад валютын цэвэр өр төлбөртэй буюу бусад сектор дахь гадаад валютын хөрөнгө нь гадаад валютын өр төлбөрөөсөө бага секторууд нь улсын болон хувийн ААН-үүд 123.6 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын, Засгийн газар 25.9 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын, хадгаламжийн байгууллагууд 7.7 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын, БСБ 0.1 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютаар хөрөнгө нь өр төлбөрөөсөө бага байна (Хүснэгт 11). Өөрөөр хэлбэл эдгээр секторууд нь гадаад валютын өр төлбөрөө хөрвүүлж төгрөгийн хөрөнгө болгож байршуулжээ. Энэ тохиолдолд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад гадаад валютын дахин үнэлгээний алдагдал хүлээдэг.

Хүснэгт 11. Гадаад валютын цэвэр хөрөнгө, их наяд ₮

2024								
Хөрөнгө Өр төлбөр	ЗГ	МБ	Хад/ байгууллага	БСБ	Улсын болон хувийн ААН	Иргэд	Оршин суугч бус	НИЙТ
Засгийн газар		5.3	-2.4	-0.1	0.0	0.0	-28.7	-25.9
Монголбанк	-5.3	0.0	-4.3	0.0	0.0	0.0	15.1	5.5
Хадгаламжийн байгууллага	2.4	3.5	0.0	-1.1	-5.5	-0.8	-6.1	-7.7
БСБайгууллага	0.1	0.0	1.1	-0.1	0.7	0.0	-1.8	-0.1
Улсын болон хувийн ААН	0.0	0.0	5.5	-0.7	0.0	0.0	-128.4	-123.6
Иргэд	0.0	0.0	0.8	0.0	0.0	0.0	0.0	0.8
Оршин суугч бус	28.7	- 15.1	6.6	1.8	128.4	0.0	0.0	150.4

Тайлбар : Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЗХ; БСБайгууллага- ББСБ, МУХБ, МИК Холдинг ХХК, Даатгалын компаниуд, ҮЦСК ХХК. Оршин суугч бус- Гадаадын санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагууд.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Гадаад валютын хөрөнгөөр гадаад валютын өр төлбөрөө хэдэн удаа төлөх чадвартай эсэх харьцааг авч үзэхэд 1-с доош буюу гадаад валютын дахин санхүүжилт авч өр төлбөрөө төлөхөөр байгаа секторууд нь БСБ, хадгаламжийн байгууллагууд, Засгийн газар, улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Гадаад валютын хөрөнгө/өр төлбөр

Оршин суугч бус	Иргэд	Монголбанк	БСБ	Хад/байгууллагууд	Засгийн газар	Улсын болон хувийн ААН
5.46	5.11	1.41	0.98	0.63	0.18	0.14


Эх сурвалж: Судлаачийн дүрслэл, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

4.4 Өөрийн хөрөнгийн бүтцийн нийцгүй байдал

Секторуудын хувьд өөрийн хөрөнгийн бүтцийн нийцгүй байдал харилцан ялгаатай байна. Засгийн газрын өөрийн хөрөнгө 19.7 их наяд, хадгаламжийн байгууллагуудынх 7.0 их наяд, БСБ-уудынх 4.6 их наяд, Монголбанкных -4.9 их наяд төгрөг байна. Төлбөрийн чадварын нийцгүй байдлын харьцаа буюу нийт өр төлбөрийн хэдэн хувийг өөрийн хөрөнгөөр барагдуулах чадвартай байгааг авч үзэхэд, Засгийн газар 36%, хадгаламжийн байгууллагууд 9%, БСБ 27% байна.

Өөрийн хөрөнгө-зээлийн харьцаа нь зээлийн өр төлбөрийг өөрийн хөрөнгөтэй харьцуулснаар тухайн байгууллага өөрийн санхүүжилтээс бус зээлийн санхүүжилтээс хамааралтай болсон эсэхийг харуулдаг бөгөөд 1-с бага харьцаатай байх нь хамааралтай болж буйг илтгэдэг. Энэхүү харьцаа нь Засгийн газарт 2.8, хадгаламжийн байгууллагуудын хувьд 0.9, БСБ-ынх 0.7 байна (Зураг 8).

Зураг 8. Өөрийн хөрөнгийн бүтцийн нийцгүй байдал



Тайлбар: Өөрийн хөрөнгө-Зээлийн харьцаа=Өөрийн хөрөнгө/Зээлийн өр төлбөр

Төлбөрийн чадварын нийцгүй байдал=Нийт өр төлбөр/Өөрийн хөрөнгө


Эх сурвалж: Судлаачийн дүрслэл, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

4.5 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн шинжилгээ

Гадаад валютын ханш чангарах нь гадаад валютаарх хөрөнгө (ханшийн тэгшитгэлийн орлого)-ийг нэмэгдүүлэх, гадаад валютын өр төлбөр (ханшийн тэгшитгэлийн зарлага)-ийг нэмэгдүүлэх нөлөөтэй байдаг. Үүнийг тооцоходоо секторуудын гадаад валютын цэвэр өглөг, авлага нь валютын ханшийн өөрчлөлтөөс шууд хамааралтай байхаар авч үзэж, гадаад валютын шокийн шууд бус нөлөө (indirect transmission effects)-г оруулаагүй болно.

Матрицад төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн 10 хувийн сулралтын үзүүлэх нөлөөг авч үзэхэд Монгол Улсын цэвэр өр төлбөр ДНБ-ний 18.9%-тай тэнцүү хэмжээгээр нэмэгдэж байна. Сектороор задалбал, Монголбанканд ДНБ-ний 0.7%-тай тэнцэх хэмжээгээр ханшийн тэгшитгэлийн ашгийг нэмэгдүүлж байгаа бол Засгийн газрын ханшийн тэгшитгэлийн алдагдлыг ДНБ-ний 3.2%-тай тэнцэх хэмжээгээр, хадгаламжийн байгууллагуудад ДНБ-ний 1.0%, бусад санхүүгийн байгууллагуудад ДНБ-ний 0.01%-тай тэнцэх хэмжээгээр тус тус нэмэгдүүлж байна (Зураг 9).

Зураг 9. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 10%-иар сулрахад үүсэх нөлөө, нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар, 2024 оны байдлаар



Тайлбар: Монголбанк нь Монгол Улсын гадаад валютын нөөцийг удирддаг тул ханшийн тэгшитгэлийн ашигтай гарсан байна. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны эцсийн байдлаар санхүүгийн тайланд 3,420 байв. Түүнчлэн матрицыг байгуулахдаа гадаад валютаар ам.долларыг төлөөлүүлсэн бөгөөд секторуудын гадаад валютын хөрөнгө, өр төлбөрийн бүтэц ам.доллороос бусад валютаар байх боломжтой.

V. Дүгнэлт

Энэ ажлаар Монгол Улсын эдийн засгийн секторуудын санхүүгийн уялдаа, холбоог судалж танилцууллаа. Эдийн засаг дахь нийт санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь 2024 оны байдлаар 387 их наяд төгрөг байгаа бөгөөд төгрөгөөр 142 их наяд, гадаад валютаар 244 их наяд төгрөг байна. Үүнээс Монгол Улсын иргэд, ААН нь оршин суугч бусад төлөх 184 их наяд төгрөгийн гадаад валютын өр төлбөртэй байгаа бол 34 их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгөтэй байна. Түүнчлэн төгрөгийн ам.доллартой харьцах ханш 10 хувиар сулрахад Монгол Улсын цэвэр өр төлбөр ДНБ-ний 19%-тай тэнцүү хэмжээгээр нэмэгдэж байгаа нь валютын ханшийн болон хүүний өөрчлөлтөд эмзэг буюу гадаад зээлийн төлбөрийн зардал нэмэгдэх, дахин санхүүжүүлэхэд хүндрэл тулгарах эрсдэлтэй байна. Ханшийн эрсдэлд эмзэг секторууд нь Засгийн газар, улсын болон хувийн хэвшлийн ААН-үүд, хадгаламжийн байгууллагууд, БСБ-ууд байв.

Түүнчлэн Засгийн газар нийт өр төлбөрийн 36%-ийг өөрийн хөрөнгөөр барагдуулах чадамжтай байгаа бол хадгаламжийн байгууллагууд 9%, БСБ 27% байна. Мөн өөрийн хөрөнгө-зээлийн харьцаа нь хадгаламжийн байгууллагууд болон БСБ-уудын хувьд 1-ээс доогуур байгаа нь өөрийн хөрөнгөөр бус зээлийн санхүүжилтээс тодорхой хэмжээнд хамааралтай байгааг харуулж байна.

Секторууд гадаад валютын санхүүжилтэд түшиглэх, мөн өөрийн хөрөнгийн бүтцийн харьцаа нийцгүй байх нь валютын ханшийн нийцгүй байдлыг үүсгэх, санхүүгийн тогтвортой байдалд тодорхой эрсдэл дагуулж болохыг олон улсын туршлага харуулдаг. Иймээс энэ чиглэлд анхаарч, зохих хяналтыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Энэхүү ажил нь бусад санхүүгийн байгууллагуудын мэдээллийг өргөн хүрээтэйгээр оруулж тооцсоноороо онцлог юм. Цаашид энэхүү матрицыг макро эдийн засгийн судалгаа хийх, сценарь шинжилгээнд ашиглах боломжтой.

Ашигласан материал

- Allen, M., Rosenberg, C., Keller, C., Setser, B., & Roubini, N. (2002). *A Balance Sheet Approach to Financial Crisis*. Олон Улсын Валютын сан:
<https://www.imf.org/external/pubs/ft/wp/2002/wp02210.pdf>-ээс Гаргасан
- Mislav Brkić. (2021). Costs and benefits of government borrowing in foreign currency: is it a major source of risk for EU member states outside the euro? *PSE Journal*.
- Zhuang, J., & Dowling, M. J. (2002). Causes of the 1997 Asian Financial Crisis: What can an Early Warning System Model Tell Us? *ERD working paper series No.26, ADB*.
- Ган-Очир, Д., Номин, С., Мөнхбаяр, Г., & Анхцэцэг, Б. (2019). Монголын эдийн засгийн эмзэг байдлын шинжилгээ: Балансын аргачлал (BSA). *Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашидын чиг хандлага*. Монголбанк.
- Дөлгөөн, Л., & Мөнхбаяр, Б. (2017). Балансын аргачлалд суурилсан макро эдийн засгийн эрсдэлийн шинжилгээ. *Судалгааны товхимол 12*, 66-86.
- МИК ОССК, Монгол Улсын Хөгжлийн Банк, Банк бус санхүүгийн байгууллага. (2025). *Тайлан тэнцэл*.
- МИК Холдинг ХК. (2025). *Жилийн тайлан*. <https://www.mik.mn/mn/m332>-ээс Гаргасан
- Монголбанк. (2019-2023). *Гадаад секторын статистик*.
- Монголбанк. (2025). *Гадаад секторын статистик*. <https://stat.mongolbank.mn/>-ээс Гаргасан
- Монголбанк. (2025). *Мөнгө, санхүүгийн статистик*. <https://stat.mongolbank.mn/>-ээс Гаргасан
- Монголбанк, Сангийн яам. (2017). *Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар*.
https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20180205_3848.pdf-ээс Гаргасан
- Олон Улсын Валютын Сан. (2011, 2014). *Хяналтын тайлан*.
- Олон Улсын Валютын Сан. (2016). *Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага*.
<https://www.imf.org/~media/Files/Data/Guides/mfsmcg-final.ashx>-ээс Гаргасан
- Санхүүгийн Зохицуулах Хороо. (2025). *Салбаруудын нэгтгэл*.
<https://www.frc.mn/#/doc/file?id=29>-ээс Гаргасан
- Үндэсний Аудитын газар. (2025). *Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан*.
- ҮЦСК ХХК. (2025).
- Олон улсын валютын сан. (2016). *Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага*. ОУВС.
<https://www.imf.org/~media/Files/Data/Guides/mfsmcg-final.ashx>
- Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар, 2017 Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаал

Хавсралт

Хавсралт 1. Балансын аргачлалын матриц, ДНБ-д эзлэх хувиар, 2024 оны байдлаар

	2024															
	Засгийн газар		Монголбанк		Хадгаламжийн байгууллага		БСБ		Улсын болон хувийн ААН		Иргэд		Оршин суугч бус		НИЙТ	
	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П
Засгийн газар			5.6	6.9	2.8	3.8	0.1	0.1	1.4	2.6	0.1	0.5	28.7	0.0	38.8	13.9
Төгрөгийн			5.6	1.6	0.0	3.4	0.1	0.1	1.4	2.6	0.1	0.5	0.0	0.0	7.2	8.2
Гадаад валютын			0.0	5.3	2.8	0.4	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	28.7	0.0	31.6	5.7
Монголбанк	6.9	5.6			22.7	4.4	0.2	3.1	0.0	0.9	0.5	0.0	3.7	18.8	33.9	32.8
Төгрөгийн	1.6	5.6			18.3	4.4	0.2	3.1	0.0	0.9	0.5	0.0	0.0	0.0	20.6	13.9
Гадаад валютын	5.3	0.0			4.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	3.7	18.8	13.4	18.9
Хадгаламжийн байгууллага	3.8	2.8	4.4	21.8	3.1	3.8	2.5	2.4	16.2	14.8	31.5	22.5	9.1	2.9	70.7	71.1
Төгрөгийн	3.4	0.0	4.4	18.2	1.9	2.7	1.3	2.3	8.6	12.6	30.6	22.4	0.0	0.0	50.3	58.3
Гадаад валютын	0.4	2.8	0.0	3.5	1.2	1.2	1.2	0.1	7.7	2.2	0.9	0.1	9.1	2.9	20.4	12.8
БСБ	0.1	0.1	3.1	0.2	2.3	1.3	0.8	1.5	0.4	2.2	5.3	9.6	0.0	0.0	12.0	14.9
Төгрөгийн	0.1	0.1	3.1	0.2	2.3	1.3	0.8	1.5	0.4	2.2	5.3	9.6	0.0	0.0	12.0	14.9
Гадаад валютын	0.0	0.1	0.0	0.0	0.1	1.2	0.2	0.1	0.1	0.7	0.1	0.1	2.0	0.2	2.5	2.4
Улсын болон хувийн ААН	2.6	1.4	0.9	0.0	14.8	16.2	3.0	0.4			0.0	0.0	140.2	11.8	161.4	29.9
Төгрөгийн	2.6	1.4	0.9	0.0	12.6	8.6	2.2	0.4			0.0	0.0	0.0	0.0	18.3	10.4
Гадаад валютын	0.0	0.0	0.0	0.0	2.2	7.7	0.7	0.1			0.0	0.0	140.2	11.8	143.1	19.5
Иргэд	0.5	0.1	0.0	0.5	22.5	31.5	9.7	5.4	0.0	0.0			0.0	0.0	32.7	37.5
Төгрөгийн	0.5	0.1	0.0	0.5	22.4	30.6	9.6	5.3	0.0	0.0			0.0	0.0	32.6	36.5
Гадаад валютын	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.9	0.1	0.1	0.0	0.0			0.0	0.0	0.2	1.0
Оршин суугч бус	0.0	28.7	18.9	3.8	2.9	9.5	0.2	2.0	11.8	140.2	0.0	0.0			33.7	184.1
Төгрөгийн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			0.0	0.0
Гадаад валютын	0.0	28.7	18.9	3.8	2.9	9.5	0.2	2.0	11.8	140.2	0.0	0.0			33.7	184.1
НИЙТ	13.9	38.8	32.9	33.1	71.2	71.8	16.7	15.0	29.9	161.4	37.5	32.7	183.7	33.7	385.8	386.6
Төгрөгийн	8.2	7.2	14.1	20.5	57.6	51.0	14.2	12.7	10.4	18.3	36.5	32.6	0.0	0.0	141.0	142.3
Гадаад валютын	5.7	31.6	18.9	12.6	13.6	20.8	2.5	2.3	19.5	143.1	1.0	0.2	183.7	33.7	244.8	244.3

Тайлбар : Хадгаламжийн байгууллага - Банк, ХЗХ; БСБайгууллага - БСБ, МУХБ, МИК Холдинг ХХК, Даатгалын компаниуд, УЦСК ХХК.

А-Актив, П-Пассив

Байгууллагуудын бүртгэл, тооцоолоос шалтгаалан нийт актив, пассив тэнцэхгүй байж болно.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Хавсралт 2. Балансын аргачлалын матриц, ДНБ-д эзлэх хувир, 2024 оны байдлаар

	2024															
	Застгийн газар		Монголбанк		Хадгаламжийн байгууллага		БСБ		Улсын болон хувийн ААН		Иргэд		Оршин суугч бус		НИЙТ	
	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П	А	П
Застгийн газар			7%	9%	3%	5%	0%	0%	2%	3%	0%	1%	36%	0%	49%	17%
Төгрөгийн			7%	2%	0%	4%	0%	0%	2%	3%	0%	1%	0%	0%	9%	10%
Гадаад валютын			0%	7%	3%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	36%	0%	39%	7%
Монголбанк	9%	7%			28%	5%	0%	4%	0%	1%	0%	0%	5%	24%	42%	41%
Төгрөгийн	2%	7%			23%	5%	0%	4%	0%	1%	0%	0%	0%	0%	26%	17%
Гадаад валютын	7%	0%			5%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	5%	24%	17%	24%
Хадгаламжийн байгууллага	5%	3%	6%	27%	4%	5%	3%	3%	20%	19%	39%	28%	11%	4%	88%	89%
Төгрөгийн	4%	0%	6%	23%	2%	3%	2%	3%	11%	16%	38%	28%	0%	0%	63%	73%
Гадаад валютын	0%	3%	0%	4%	1%	1%	2%	0%	10%	3%	1%	0%	11%	4%	26%	16%
БСБ	0%	0%	4%	0%	3%	3%	1%	2%	1%	4%	7%	12%	2%	0%	18%	22%
Төгрөгийн	0%	0%	4%	0%	3%	2%	1%	2%	0%	3%	7%	12%	0%	0%	15%	19%
Гадаад валютын	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	1%	0%	0%	2%	0%	3%	3%
Улсын болон хувийн ААН	3%	2%	1%	0%	19%	20%	4%	1%			0%	0%	175%	15%	202%	37%
Төгрөгийн	3%	2%	1%	0%	16%	11%	3%	0%			0%	0%	0%	0%	23%	13%
Гадаад валютын	0%	0%	0%	0%	3%	10%	1%	0%			0%	0%	175%	15%	179%	24%
Иргэд	1%	0%	0%	1%	28%	39%	12%	7%	0%	0%			0%	0%	41%	47%
Төгрөгийн	1%	0%	0%	1%	28%	38%	12%	7%	0%	0%			0%	0%	41%	46%
Гадаад валютын	0%	0%	0%	0%	0%	1%	0%	0%	0%	0%			0%	0%	0%	1%
Оршин суугч бус	0%	36%	24%	5%	4%	12%	0%	2%	15%	175%	0%	0%			42%	230%
Төгрөгийн	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%			0%	0%
Гадаад валютын	0%	36%	24%	5%	4%	12%	0%	2%	15%	175%	0%	0%			42%	230%
НИЙТ	17%	49%	41%	41%	89%	90%	21%	19%	37%	202%	47%	41%	230%	42%	483%	484%
Төгрөгийн	10%	9%	18%	26%	72%	64%	18%	16%	13%	23%	46%	41%	0%	0%	176%	178%
Гадаад валютын	7%	39%	24%	16%	17%	26%	3%	3%	24%	179%	1%	0%	230%	42%	306%	306%

Тайлбар : Хадгаламжийн байгууллага- Банкууд, ХЭХ; БСБайгууллага- БСБ, МУХБ, МИК Хойдинг ХХК, Даатгалын компаниуд, УЦСК ХХК.

А-Актив, П-Пассив

Эх сурвалж: Судлагчийн тооцоолол, Хүснэгт 6-д дурдсан эх сурвалжууд

Хавсралт 3. Матрицын нөхцөлүүд

Монголбанк						
	Засгийн газар	Төв банк	Хадгаламжийн байгууллагууд	БСБ	Улс, хувийн байгууллага, иргэд	Оршин суугч бус
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	30%		20%	7%	43%	
Өөрийн хөрөнгө	100%					
Бусад актив			47%		5%	
Банкууд, ХЗХ						
	Засгийн газар	Төв банк	Хадгаламжийн байгууллагууд	БСБ	Иргэд	Оршин суугч бус
Бусад актив			100%			
Бусад пассив			100%			
Өөрийн хөрөнгө			1%	6%	94%	
Гадаад валютын нөөц						
	Засгийн газар	Төв банк	Хадгаламжийн байгууллагууд	БСБ	Иргэд	Оршин суугч бус
ГВАН		100%				

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

	Хадгаламжийн байгууллагууд	БСБ	Улсын болон хувийн ААН
Актив “Бусад сектор”		2%	98%
Пассив “Бусад сектор”		7%	93%

Тайлбар: БСБ-уудын 2%, 7%-ыг тооцохдоо БСБ-уудын балансыг ашиглав.

Шууд хөрөнгө оруулалт

	Хадгаламжийн байгууллагууд	БСБ	Улсын болон хувийн ААН
Актив “Бусад сектор”			100%
Пассив “Бусад сектор”			100%